

**2019.09.23-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2019.09.27

Дархан

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариу цах эзэн	Хэрэгжилт
1	Найрамдал талбайд хөшөө барих, нэрэмжит болгох асуудлаар холбогдох журмыг судлаад танилцуул	ХЭЗХ	Хэрэгжилтийг хангаж ажилласан.
2	Орхон сумын цэцэрлэгийн насосын асуудлыг шийдвэрлэ	ЗА	ДДС ТӨХК-ийн засварчдаар насосыг засварлуулж хүлээлгэн өгсөн.
3	Орхон сумын гэр хороолол дахь цэцэрлэгийн хэвийг үйл ажиллагааг хангах	Орхон сумын ЗДТГ	Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа.
4	Орхон сумын нутаг дэвсгэр Ноён Хонгорт 20 га талбайн асуудлыг шийдвэрлэсэн. Хэний нэр дээр бүртгэх талаар тодорхой болгох	Орхон сумын ЗДТГ	Тогтоол ирээгүй байна.
5	Дархан сумын мал бүхий иргэдийг Хонгор суманд гаргах дэд бүтцийн төсөв, тооцоог эргэж судлаад танилцуул	Дархан сумын ЗДТГ	Тооцоог хийж аймгийн Засаг даргад танилцуулсан.
6	Би Эс Би худалдааны төвийн урд ногоо худалдаалах цэг нэмэх асуудлаар судалж танилцуул	ХОХБТХ	Сумдын Засаг дарга нарт нутаг дэвсгэртээ хүнсний ногоо худалдаалах цэгүүдийг судлах тухай албан бичгүүдийг хүргүүлсэн.
7	Орхон сумын хаалган дээр байгаа ногоо худалдаалах цэгийг ажилд оруулах	Орхон сумын ЗДТГ	Журмын дагуу 2 удаа нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан боловч иргэн, аж ахуйн нэгжээс материал ирүүлээгүй.
8	Нийтийн орон сууцанд тархсан шоргоолж, хортон шавьжийг устгах судалгаа, тооцоог хийж яаралтай танилцуулах	Дархан сумын ЗДТГ, ЗА	Дархан сумын 7 багийн 32 байранд 18200м2 талбайд “Мөнжөөлэй” ХХК нь 8 дугаар сарын 9-ний өдрөөс 9 дүгээр сарын 30-ний өдрийн хугацаанд 5,4 сая төгрөгийн өртөгтэйгөөр зоорийн давхарт ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж дуусгасан.
9	Вокзалын павильоны ашиглалтыг сайжруулах, зориулалтын дагуу ажиллуулах талаар арга хэмжээ авч танилцуулах	Дархан сумын ЗДТГ	
10	Дахин төлөвлөлтөөр баригдсан байранд орох 4,5 дугаар байрны айлуудтай уулзалт хийж ойлголцох. Биелэлтийг эргэж танилцуулах	Дархан сумын ЗДТГ	
11	Архивын улсын үзлэгтэй холбогдуулан аймгийн үзлэгийг өндөр хэмжээнд гүйцэтгэж дуусгах	ХЭЗХ	
12	Хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллөөр нөхөрлөлүүдэд шүүх дээр хэрэг үүсгэгдсэн байна.	ХЭЗХ, ХОХБТХ	

	Хэргийг тодорхой болгож танилцуулах		
13	Намрын тариа хураалтад хүн хүчээ зөв хуваарилж ажиллуулах. Хаанаас ямар хүн авч ажиллуулах вэ? Мэдээлэл бэлтгэж танилцуул	Орхон сумын ЗДТГ, Хонгор сумын ЗДТГ	Намрын тариа хураалтад ААНБ-ууд 40 орчим иргэнийг түр ажлын байраар ханган ажиллуулж байна.
14	Сумдууд намрын хадлан тэжээлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд анхаарал тавь.	Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумд	Аймгийн Засаг даргыг тус суманд ажиллах үед төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулсан. Өнгөрсөн жилийн зарцуулагдаагүй 50 тн өвс, 13,5 тн хивэг нөөцөд байгаа. Нэмж 12,5 тн хивэг худалдаж авахаар төлөвлөн ажиллаж байна.
15	Салхит багт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн дулааны асуудлыг 10 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө шийдвэрлэж дуусгах	ЗА	Зүүнхараа дахь УБТЗ-ийн барилга угсралтын 1-р ангийн дарга Б.Гансүх, инженер Ганжигүүр нартай утасаар ярьж 11-р сургуулийн гадна дулааны шугамын угсралтын ажлыг ирэх долоо хоногт хийхээр болсон. Материал татан авалт хийгдсэн.
16	Дулаан Шарын гол ХК-тай Шарын голын ААН байгууллагууд гэрээ байгуулдаг. Ямар шатанд явж байгаа вэ? Бэлтгэлийг хангуулах	ЗА	Шарын голын Засаг дарга, “Дулаан шарын гол” ТӨХК хооронд Шарын гол сумын Эмнэлэгийн дулаан, цэвэр усны шугам сольж засварлах ажлын гэрээ хийж 10-р сард хийж гүйцэтгэх болсон.
17	Хонгор суманд орон сууцны 20 айлын ялтсан халаалтын бойлур ажиллахгүй байгаа шалтгааныг тодруулж танилцуулах	ЗА	Орон сууцны айлууд халаалтаа 100% бүрэн авсан.
18	Орхон суманд дээвэр засварын ажил яагаад саатаад байгаа вэ?	ХОХБТХ ДХББЗГ ОНӨ-ААТҮГ	2-р үеийн хар цаас наах ажил хийгдэж байна. Ажлын явц 90 хувьтай байна.
19	Дархан суманд дулаан аваагүй ААНБ-ын судалгааг гаргаж танилцуулах	ЗА	Оюуны ирээдүй цогцолбор сургууль 10 дугаар сарын 1-ээс дулаанаа авахаар гэрээ хийсэн байгаа. Хонгор сумын Салхит багийн 11 дүгээр сургуулиас бусад сургууль цэцэрлэгүүд халаалтаа бүрэн авсан.  ААНБ-ын дулааныг 10 дугаар сарын 1-ээс холбосон.
20	Шинээр тавьсан асфальтан замын ашиглалтад анхаарах. Цэвэрлэгээ үйлчилгээг явуулах	ЗА, НААҮГ	Мангирт, тосгоны чиглэлийн шинээр тавигдсан авто замыг НААҮГ-ын зам талбайн 1, 4 дүгээр хэсгийн ажилчдаар цэвэрлүүлж чийгжүүлсэн.
21	Хотын дотор замын нөхөөс, замын гагнаас хийгдээгүй байна. Хурд сааруулагч будагдаагүй. Энэ 7 хоногт дээрх ажлуудыг хийж	ХОХБТХ	Явган хүний гарц болон хурд сааруулагчийн будгийг тодруулах ажил төлөвлөгдсөнөөс 67,4 хувь

	дуусгах		буюу 2696 у/м хийгдээд байна.  Авто замын торон хагарлыг гагнах ажил хийгдэж байгаа.
22	Дархан-Ус Суваг ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлсөн тогтоолыг дахин засварлаж гаргах	ОНӨГ	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Дархан Ус суваг” ХК-ний ТУЗ-ийн бүрэлдхүүнээс чөлөөлөх тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, төлөөлөгчдийн саналаар тогтоолын төслийн 2 дахь заалтыг /ТУЗ-ын гишүүнээр томилох тухай / хасч М.Жаргалсайханыг тус компаний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй” гэсэн 1 заалттайгаар тогтоолыг баталсан.
23	Албан тушаалын байрыг тэтгэвэрт гарсан хүнд шилжүүлдэг буруу жишиг тогтож байна. Холбогдох хуулийн дагуу судалж танилцуулах, шийдвэрлэх	ОНӨГ	Тус газрын зүгээс орон нутгийн өмчид хамаарах орон сууцыг хувь хүний өмчлөлд шилжүүлэх асуудлыг дэмжихгүй байр суурьтай байдаг. Цэргийн штабын даргаар ажиллаж байгаад 2018 онд өндөр насны тэтгэвэрт гарсан хурандаа Ц.Энхтөр амьдарч байсан орон сууцаа /АЗДТГ-ын балансад бүртгэлтэй/ хувьчилж авах хүсэлт гаргасныг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар тогтоолын төсөл хэлэлцүүлсэн /2019,09,20-ны хурлаар/ ч хувьчлалын асуудал учраас Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал тул Төлөөлөгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсон.
24	Төсвийн зарим байрууд ОНӨГ-т зарим нь тухайн байгууллага дээрээ баланстай байна. Үүнийг цэгцэлж нэг болгох	ОНӨГ	Дахин төлөвлөлтийн хүрээнд баригдсан 60 айлын орон сууцнаас 12 байр Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй. Тус газарт бүртгэлтэй өөр орон сууц байхгүй болно.
25	Төмөр замын вокзалын хашаа руу тойрч ордог зам хэний өмч вэ? Мөнгө хураагаад байна.	ОНӨГ	Дархан төмөр замын өөрийн эзэмшлийн авто зогсоол орон нутгийн өмчлөлд хамаарахгүй бөгөөд зөвхөн зорчих хэсгийн зам хамаарна.
26	2020 оны хөрөнгө оруулалтын ажлын саналуудаа эрэмбэлж бэлтгэх	ХОХБТХ	2020 оны хөрөнгө оруулалтын ажлын саналыг холбогдох газруудаас авч эрэмбэлэх ажил хийгдэж байна.
27	Аймгийн ИТХ-ын ажлын алба, хяналтын хороодыг бичил уурхайн үйл ажиллагаатай танилцуулах маршрут бэлтгэх	ХОХБТХ	Аймгийн ИТХ-ын ажлын алба, хяналтын хороодыг бичил уурхайн үйл ажиллагаатай танилцуулах маршрутыг гаргаж хэрэгжилтийг хангасан.

28	Нийтийн тээврийн автобусны үнэ тарифыг өөрчлөх асуудлаар сонгох ажиллагааг өндөр түвшинд явуулах	МТА, ХОХБТХ	2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр “Дархан хот дотор нийтийн тээврийн хэрэгсэл /Автобус/-ээр үнэ төлбөргүй зорчих эрх бүхий иргэдийн нөхөн олговрыг хуваарилах, санхүүжүүлэх түр журмын төсөл” –д иргэд олон нийтийн саналыг тусгахаар Иргэний танхим хэлэлцүүлэг зохион байгуулсан.
29	Төвийн бүсийн түншлэл үзэсгэлэн худалдааг зохион байгуулах бэлтгэл хангах	ХОХБТХ	“Төвийн бүсийн түншлэл - 2019”, “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа болох тухай хэвлэлийн бага хурлыг 2019-09-24-ний өдөр, нээлтийг нь 2019-09-27-ний өдрийн 13.00 цагт хийв. 8 аймгийн 100 гаруй бизнес эрхлэгчид оролцлоо.
30	Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үнэ тарифтай холбоотой тогтоолыг Хонгор суманд хүргүүлэх	ХОХБТХ	ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг цахимд оруулсан.
31	Бателионы авто зам хучигдахгүй байна. Хяналт тавих	ЗА, ХОХБТХ	Аймгийн ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг газар дээр нь тус ажилтай танилцаж, ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгсөн. Ажлын явц 45 хувьтай, буталсан чулуун суурийн ажил хийгдэж байна. Захиалагчийн хяналтыг “Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ хийж байгаа.
32	Намрын цэрэг татлагын бэлтгэл хангах	Цэргийн штаб	Бэлтгэл ажлыг хангах хүрээнд аймгийн Засаг даргын захирамжийг батлуулж 10 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн Шарын гол /10.07/, Орхон /10.08/, Хонгор /10.09/, Дархан /10.11-13/ сумд гэсэн дарааллаар цэрэг татлагыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Багийн Засаг дарга нар, үзлэгийн комиссийн бүрэлдэхүүнд сургалт, семинарыг зохион байгуулаад байна.
33	Театрын гадна хананд байгаа Лэд дэлгэцийг хэвийн ажиллуулах	МТА	Лэд дэлгэцээр гаргах мэдээллийн хуваарийг гарган хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.
34	Хурлын заалны цонх хагарсан байна. Үүдний харуул хамгаалалтыг чангатгах, хяналт тавих	НҮА	Хурлын заалны цонхны хэмжээг авч шинэ шилний захиалга өгсөн. 10 дугаар сарын 1-ний өдөр шил бэлэн болохоор угсарч байрлуулна. Харуул хамгаалалтыг сайжруулах талаар Харуулын албаны дарга

			Баярбаатартай уулзаж үүрэг чиглэл өгсөн.
35	ЗДҮАХ-ийн явцаар мониторинг хийж танилцуулах	ХШҮДАХ	<p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2019 оны хэрэгжилтийг эхний 9 сарын байдлаар явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд <b>“эрчимжүүлэх шаардлагатай”</b> буюу <b>40.0%-38</b>, <b>“үр дүнгүй”</b> буюу <b>0%-4</b>, <b>“үнэлэх боломжгүй”-15</b>, <b>“хугацаа болооогүй”-5</b> арга хэмжээг бүлэг, зорилт тус бүрээр ангилан жагсаалт гарган цаашид дээрх арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд анхаарах талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын хамт бодлогын хэлтсийн дарга нарт (ТЗУХ-ийн дарга П.Баярсайхан, ХЭЗХ-ийн дарга Л.Алтанчимэг, ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн М.Энхбаяр, НБХ-ийн дарга Н.Цасчихэр, Цэргийн штабын дарга Б.Болдбаатар) 2019.09.23-ны өдрийн 16 цагт Тамгын даргын өрөөнд танилцууллаа.</p> <p>Мөн аймгийн ЗДҮАХөтөлбөрийн эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын ХШҮүнэлгээ хийсэн тайлан, танилцуулга, нарийвчилсан үнэлгээг хэвлэмэл байдлаар аймгийн Засаг даргад, файлаар аймгийн Засаг даргын туслах Б.Батсайханы Бгий Бгий фэйсбүүк чатаар нь хүргүүлсэн.</p>

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ц.БОЛОРТУУЛ